



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/06

Бат-Өлзий сум

Мод бэлтгэх зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, 59.1.17, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.7 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Сумын 2023 оны хэрэглээний болон түлшний модны хуваарь батлах тухай” 2022 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 10/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 10/02 дугаар тогтоолоор баталсан мод бэлтгэх хуваарийн дагуу Ойн мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, нөхөрлөлүүдэд мод бэлтгэх зөвшөөрөл олгосугай.

2. Мод бэлтгэх зөвшөөрөл авсан Ойн мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, нөхөрлөлүүдтэй гэрээ байгуулж, эрхийн бичиг олгож ажиллахыг сум дундын Ойн ангийн инженер (Ш.Бумандолгор), Ойн ангийн техникч (А.Мягмардавга), Байгаль хамгаалагч (Ж.Батмөнх, Б.Энхмаа) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тухайн жилийн хэрэглээний мод, түлээ бэлтгэх үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Б.Янжиндулам)-д даалгасугай.

4. Ойн менежментийн төлөвлөгөөний дагуу гэрээг батлахыг сум дундын Ойн ангийн дарга (Д.Очирхуяг)-д зөвлөсүгэй.

5. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

